

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. ТҮВШИНЖАРГАЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ
ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН ГОДОРХОЙЛОЛТ

Үйлчилгээний нэр: “Багануур” ХК-ийн ажилтнуудад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж дүгнэлт гаргах

Ажил үйлчилгээний нэр: Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг

Гэрээний нөхцөл: Үйлчилгээ

Гэрээний үргэлжлэх хугацаа: 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл

Байршил: “Багануур” ХК-ийн ажлын байранд хийвэл давуу тал болно. Зайлшгүй шаардлагатай нөхцөлд тухайн эмнэлгийн байгууллага дээр үзлэг шинжилгээ хийлгэж болно.

Зарим тусгай нөхцөл шаардлагатай шинжилгээг тухайн үед тохиролцож шийдэж болно.

1. Үндэслэл:

1. Монгол Улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 44 дүгээр зүйл,
2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 14 дүгээр зүйл,
3. Эрүүл мэндийн Сайдын 340 тоот тушаалыг хэрэгжүүлэх
4. “Багануур” ХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны 2023, 2024 онд хийгдэх хамтын гэрээний 4.3.11 дэх заалтыг хэрэгжүүлэх

2. Зорилго:

“Багануур” ХК-ийн ажилтнуудыг зонхилон тохиолдож байгаа ууц нурууны мэдрэлийн өвчлөл болон зүрх судасны өвчнийг эрт илрүүлэх, оношлох улмаар эмчилгээнд хамруулах, хүндрэлээс сэргийлэх, дүгнэлт гаргах зорилготой.

3. Хамрах хүрээ:

“Багануур” ХК-ийн хөдөлмөрийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажилладаг нийт ажилтныг хамруулна.

4. Хийгдэх үзлэг шинжилгээг зүрх судасны болон ууц нурууны мэдрэлийн өвчний гэсэн 2 багц болгон хамруулахаар доор хүснэгтээр харууллаа.

Үүнд: Зүрх судасны багц

№	Үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нар, шинжилгээний төрөл	
1	Зүрх судас	
2	Дотор / Элэг цөс, Бөөр шээс ялгаруулах тогтолцоо гэж задарч болно /	
3	Нүд / Нүдний уг дурандах /	
4	Багажийн шинжилгээ	Зүрхний цахилгаан бичлэг
5		Зүрхний ЭХО
6		Холтер, Титэм судасны КТГ, ачаалалтай сорил, / шаардлагатай тохиолдолд /
7		Хэвлийн ЭХО
8		Цээжний рентген зураг /флюор
9	Элэг цөсний үйл ажиллагаа	Алат
10		Асат
11		Гаммаглутамилтрансфераза
12		Нийт билирубин
13		Шүлтлэг фосфатаза
14	Өөх тос, нүүрс усны солилцоо	Холестрин
15		Триглицерид
16		Сахар / шаардлагатай тохиолдолд 3 сарын дундаж сахар /
17		Бага нягтралтай өөх тос
18		Их нягтралтай өөх тос
19	Иммунологийн шинжилгээ	ASLO, CRB, RF,
20		Шаардлагатай тохиолдолд өвөрмөц уураг,энзим
21	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	
22	Шээсний ерөнхий шинжилгээ	

Ууц нурууны мэдрэлийн багц:

№	Үзлэг хийх нарийн мэргэжлийн эмч нар, шинжилгээний төрөл	
1	Мэдрэл	
2	Дотор	
3	Багажийн шинжилгээ	Хэвлийн ЭХО
4		Цээжний рентген зураг /флюор/
5		Зүрхний цахилгаан бичлэг
6		Нурууны КТГ, MRI шинжилгээг ЭМД оролцуулан хийх
7		Нурууны рентген зураг болон бусад шаардлагатай шинжилгээ
8	Элэг цэсний үйл ажиллагаа	Алат
9		Асат
10		Гаммаглютамилтрансфераза
11		Нийт билирубин
12		Шүлтлэг фосфатаза
13	Өөх тос, нүүрс усны солилцоо	Холестрин
14		Триглицерид
15		Сахар
16	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	
17	Шээсний ерөнхий шинжилгээ	

Зайлшгүй шаардлагатай тохиолдолд тохиромжтой хувилбараар бага зэрэг өөрчлөлт оруулах санал гаргаж зөвшилцөлд хүрч болно.

5. Ажил үйлчилгээ гүйцэтгэх байгууллагад тавигдах шаардлага:

5.1 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийх итгэмжлэл бүхий төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, лабораторитай байна.

5.2 Үзлэг хийх эмч нарын багц: Мэдрэл, дотор /хоол боловсруулах, бөөр гэх задарч болно/ нарийн мэргэжлийн ур чадвар сайтай, мэргэшлийн зэрэг цол бүхий эмч нар байна.

5.3 Ачаалалтай ажиллах чадвартай, илүү цагаар ажиллах тохиолдолд илүү цагийн хөлсийг тухайн эмнэлгийн байгууллага өөрсдөө хариуцах, хоол болон эмч нарын байрлах буудлын хөлсийг тухайн эмнэлгийн байгууллага хариуцна.

5.4 Багажийн болон лаборатори шинжилгээ хийх аппарат багаж тоног төхөөрөмж нь стандарт чанар аюулгүй байдал хангасан, сүүлийн үеийн, өндөр үзүүлэлттэй байх.

6. Ажлын тайлагнал:

6.1 Ажлыг гүйцэтгэх явцад захиалагч "Багануур" ХК-ийн нууцад хамаарахаас бусад шаардлагатай мэдээллээр хангана.

6.2 Үзлэгийн төгсгөлд ажилтан бүрийн үзлэгийн ерөнхий дүгнэлтийг бичиж гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байх ба компанийн хэмжээнд тохиолдож байгаа өвчлөл, өвчлөлийг хэрхэн бууруулах талаар зөвлөмж дүгнэлт гарган, танилцуулгыг /word, powerpoint/ компанийн удирдлагын баг болон ажилтнуудад тайлагнана.

6.3 Ажлын дүгнэлт тайланг цаасан болон цахим хэлбэрээр компанид үлээлгэж өгнө.

6.4 Тус ажлын удирдамжид талуудын зөвшилцлийн үндсэн дээр ажлын амрах хүрээ, зорилгод өөрчлөлт оруулж болно.

ХЯНАСАН:

ХАБЭАХ-Н ДАРГА

Ч.АРИУНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ҮЙЛДВЭРИЙН ЭМЧ

Д.ТҮВШИНБАЯРМАА